

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Монголын геологи хайгуулын нэгдсэн системтэй боллоо

Д.МӨНХ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсын геологийн мэдээллийн каталоги системийг танилцуулав. Энэхүү системийг **Австрали** улсын Засгийн газрын "Америк" хөтөлбөрийн санхүүжилтээр "Оюуны цоморлиг импекс" компанийн мэргжилтнүүд таван сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. Монгол Улсын геологийн мэдээллийн бүх тайланг онлайн орчинд түргэн шуурхай хэрэглэж ашиглах боломжийг бүрдүүлж байгааг тус компанийн Газарзүйн сангийн мэргжилтэн Д.Дэжидмаа онцолж байлаа. Үүнийг зөвхөн геологийн салбарынхан төдийгүй сонирхсон хүн бүхэн үзэж судлах боломжтой юм. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-ын үйл ажиллагааны хөтөлbert тусгасан геологийн мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлж, хэрэглэгчдэд хүндрэлгүй, бодитоор хүргэх Монгокат системийг энэ оны деревдүгээр улирлаас эхлэн ашиглах юм. "Энэхүү систем нь УУХҮЯ болон АМГТГ-ын Үндэсний геологи, эрдэс баялагийн мэдээллийн сан байгуулах ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн томоохон хөтөлбөрийн нэг болж байна" гэж УУХҮЯ-ны Териин нарийн бичгийн дарга Г.Нандинтушиг онцолсон юм.

Монгокат систем нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд геологийн мэдээллийн эх үүсвэрийн талаарх товч мэдээллийг авах боломжтой юм байна.

Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг нь цахим сүлжээний орчинд орон зайн хайлт хийх боломжийг олгож байгаа газарзүйн мэдээллийн систем бөгөөд энэ нь дэлхий дахины 90 хувь нь ашигладаг Arcgis программд сууриссан, орчин үеийн хамгийн хүчирхэг систем болохыг "Оюуны цоморлиг импекс" компанийн захирал, доктор С.Амарсайхан онцолж байлаа. Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь геологийн мэдээллийн тухай хураангуйг тулхуур үзээр хайх метадата-каталоги систем. Энэ нь Geonetwork программд сууриссан, мэдээллийг хэрхэн, хэн бэлтгэсэн тухай өгүүлдэг бөгөөд ерөнхийдөө Монгокат систем нь сансрын зураг ашиглан, ашигт малтмалын орд, тэдгээрийн суурь болон жижиг, дунд геологийн зураглалыг харуулдаг аж. Товчхондоо, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа төрөл бүрийн ашигт малтмалын геологи хайгуулын ажлын үр дүнг товч бөгөөд тодорхой харуулах мэдээллийн сан юм. Энэхүү санд 1914 оноос хойш Монгол Улсад хувийн болон териин санхүүжилтээр хийсэн геологи хайгуулын бүх ажил, түүний үр дүнгийн тухай мэдээлэл хуримтлагдаж байна.